



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2019 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 04

Ховд

「 Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл
ажил хангах тухай

Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангаж 2019-2020 оны өвөлжилт, хаврыг тав тухтай даван туулах зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг сум, албан байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт.

1.1. Ажилчдынхаа ажил, амралтын хуваарийг сайтар зохион байгуулж, өвөлжилтийн бэлтгэлийг хангахад онцгой анхаарч 2019-2020 оны өвлийн бэлтгэл хангуулах ажлын хэсгийг 06 дугаар сард багтаан томилж, хийх ажлын чиглэл, ажлын төлөвлөгөө гарган биелэлтэнд хяналт тавьж ажиллах.

1.2. Байгууллагын халаалтын шугам сүлжээний урсгал болон их засварыг 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүрэн хийж дуусган шалгаж хүлээн авах.

1.3. Жилийн хэрэгцээт нүүрс, түлшний 30-аас доошгүй хувийг 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, үлдэх хэсгийг 10 дугаар сарын 15-ны дотор татаж нөөцлөх ажлыг зохион байгуулах.

1.4. Байгууллагын урсгал болон их засварыг 09 дүгээр сарын 01-ний дотор дуусгаж хаалга, цонхны бүрэн бүтэн байдлыг шалгаж 10 дугаар сарын 01-ний дотор ажлын хэсэгт хүлээлгэн өгөх.

1.5. Хөрөнгө оруулалтаар сум, байгууллагад хийгдэж буй засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай гүйцэтгүүлэх талаар захиалагч, ашиглагч хяналтын байгууллагууд хамтран хяналт тавьж ажиллах.

Хоёр. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Дулааны станцуудын дарга, захирал нарт

2.1. Халаалтын зуухнуудын засвар үйлчилгээг чанартай хийж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг гарган нөөцөлж бэлтгэх.

2.2. Төв болон салбар шугам сүлжээний гэмтлийг шалгаж, үзлэг хийж элэгдэлд орсон цоорч болзошгүй шугам сүлжээг засварлаж 09 дүгээр сарын 01-ний дотор бүрэн хийж дуусган шалгаж хүлээн авах.

2.3. Жилийн хэрэгцээт нүүрсний 20 хувийг 09 дүгээр сарын 01-ний дотор бэлтгэж, тогтмол 5000 тн нүүрсний нөөцтэй байхаар тооцон нүүрс тээвэрлэлтийг хийж, нүүрс тээвэрлэх аж ахуйн нэгж, иргэдтэй хуулийн хүрээнд гэрээ байгуулж баталгаажуулан тээврийн хөлсийг гэрээний дагуу олгох.

Гурав. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Ховд цахилгаан түгээх Сүлжээ” ХХК-нд

3.1. Цахилгааны шугам сүлжээ, дэд станцуудын засвар үйлчилгээг чанартай хийж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах.

3.2. Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүртэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулан өр авлагыг барагдуулах.

3.3. Цахилгаан эрчим хүчний болзошгүй тасалдал гарахаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед ажиллуулах аваарын дизель станцыг бэлтгэж, түлш шатахуун нөөцлөх.

3.4. Хөдөөгийн сумдыг цахилгаан эрчим хүчээр хэвийн хангахад анхаарч, техникийн үзлэг хийж, өр авлагыг барагдуулах талаар сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах.

Дөрөв. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Шим-Ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт:

4.1. Цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар үйлчилгээг 09 дүгээр сарын 01-ний дотор бүрэн хийж дуусгах.

4.2. Өөрийн харьяалалд байгаа дулаан түгээх шугам сүлжээнд үзлэг хийж, шаардлагатай засвар үйлчилгээг 09 дүгээр сарын 01-ний дотор хийж дуусгах.

4.3. Нийтийн эзэмшлийн орон сууцны халаалтын системийн угаалгыг 2019 оны 07 дугаар сарын 20-ны дотор хийж дуусгах, СӨХ-ийн хүмүүстэй хамтран айл өрхүүдийг эзэнтэй байлгах.

4.4. Жаргалант сумын Жаргалан баг, Рашаант багийн инженерийн шугам сүлжээний ажлыг хийхэд хяналт тавьж, хамтран ажиллахыг /Д.Сурмаажав/-д үүрэг болгох.

Айл өрх, аж ахуйн нэгжүүдтэй хамтран засвар үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулахыг Дулааны станцын захирал /Д.Сурмаажав/, /Д. Энхсайхан/, Шим-Ус орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга /Л.Баатарзориг/, Ховд Цахилгаан түгээх Сүлжээ ХХК-ний захирал /Ш. Арстан/ нарт үүрэг болгох

Шугам сүлжээний засвар үйлчилгээний ажилд Бадамлах дөл ХХК-иас 15 хүн, Ховд дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаниас 15 хүн, Шим-Ус орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 15 хүн, Цахилгаан түгээх Сүлжээ ХХК-иас 10 хүн буюу нийт 55 ажилчдад 1,5 сарын цалингийн урамшуулал олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгох

Тав. Албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Т.Жаргалсайхан, Жаргалант сумын Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Гантөмөр нарт үүрэг болгосугай.

Зургаа. Албан даалгаврын тайлан мэдээг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ